



**МОНГОЛ УЛСЫН
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2014.03.11 № 1/883

танай _____-ны № _____-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНД**

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас махны хангамж, нөөцийн талаарх мэдээллийг хуваарийн дагуу хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

*Манилага
Хүндэтгэсэн
2014.03.20*



**ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

Х.ЗОЛЖАРГАЛ

00006841

МАХНЫ ХАНГАМЖ, НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

Монголбанкны ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дугаар бүхий тушаалаар батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилт:

“Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөр:

2014 оны өвөл, хаврын улирлын хүн амын хэрэгцээнд зориулж нийт 14,0 мян.тн махны нөөц бэлтгэж, сертификатаар баталгаажуулан оролцогч арилжааны банкнаас 15,400.0 сая төг (20%), Монголбанкнаас 61,600.0 сая төг (80%), нийт 77,000.0 сая төгрөгийн зээл олгосон. Үүнээс:

➤ Дархан хотод “Дархан мийт фүүд” ХХК 1,0 мян.тн нөөцийн мах бэлтгэж, 5,500.0 сая төгрөгийн зээл, Эрдэнэт хотод “Эрдмийт” ХХК-иуд 1,0 мян.тн нөөцийн мах бэлтгэж, 5,500.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авсан байна.

➤ УБ хотод “Эи Эн Ди Эм” ХХК, “Баатарууд тэнгэр” ХХК-иуд тус бүрдээ 6,0 мян.тн нөөцийн мах бэлтгэж, нийт 66,000.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авчээ.

Хөтөлбөрийн хүрээнд нөөцийн махны менежер компаниуд нийт 14.0 мянган тонн махны нөөц бэлтгэх үүрэг хүлээснээс гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Бүс	Хугацаа* /долоо хоногоор/	Үүрэгт нөөцийн хэмжээ тонноор	Нөөц бэлтгэл /тонноор/				Гүйцэтгэл
			Үхэр	Хонь	Ямаа	Нийт	
Улаанбаатар	ЭЙ ЭН ДИ ЭМ ХХК	6,000.0	1,498.1	2,757.6	2,000.9	6,256.6	104.3%
Улаанбаатар	Баатарууд тэнгэр ХХК	6,000.0	2,165.4	3,032.3	803.9	6,001.6	100.0%
Дархан уул	Дархан мийт фүүд ХХК	1,000.0	300.0	400.0	300.0	1,000.0	100.0%
Орхон	Эрдмийт ХХК	1,000.0	519.7	310.1	171.7	1,001.5	100.2%
	Нийт	14,000.0	4,483.3	6,500.0	3,276.5	14,259.7	101.9%

Нөөцийн махны худалдааг 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлсэн бөгөөд 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нөөцийн махны худалдаагаар нийт 964,23 тн (6.8%) мах борлуулсан. Үүнээс хонины мах 418,7 тн, ямааны мах 89,4 тн, үхрийн мах 456,004 тн-ийг эзэлж байна.

Махны нөөц бүрдүүлэх, түүний хэмжээ, чанар, хадгалалт, худалдан борлуулах үйл ажиллагаанд ҮХААЯ, Монголбанк, ОБЕГ, МХЕГ, Оролцогч банк байнгын хяналт тавьж ажилласнаас гадна Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Монголын махны холбоо, Эрүүл мэнд аюулгүй байдал, Хүнсний тусгаар байдлын төлөө хүмүүсийн эвсэл, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоо зэрэг төрийн бус байгууллагуудаар хөндлөнгийн хяналт тавин ажиллаж байна.